



ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
САЙД С.ЧИНЗОРИГ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЦАГ УУР, ОРЧНЫ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот,  
Чингэлтэй дүүрэг, Жуулчины гудамж 5.  
Утас: 26 41 52, Факс: (976 11) 32 66 11,  
И-мэйл: meteoagency@magicnet.mn

2018.04.03 № 1/258

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г


Урьдчилан сэргийлэх мэдээ  
хүргүүлэх тухай

**АХИУХАН ХЭМЖЭЭНИЙ ХУР ТУНАДАС, НОЙТОН ЦАС ОРЖ, ХҮЧТЭЙ ЦАСАН  
БОЛОН ШОРООН ШУУРГА ШУУРНА**

2018 оны 4 дүгээр сарын 04-нд Төв аймгийн нутаг, Завхан, Архангайн зүүн, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн хойд, Булганы өмнөд хэсгээр, 5-нд Хэнтий, Дундговь, Дорноговь, Сүхбаатарын нутаг, Төв, Дорнодын өмнөд, Өмнөговийн зүүн хэсгээр ахиухан хэмжээний хур тунадас, нойтон цас орж, цасан шуурга шуурч, хүйтэрч, зам, даваа гүвээ, цас шуурганд хаагдах, үзэгдэх орчин хязгаарлагдах, хальтиргаа гулгаа үүсэх нөхцөл бүрдэж байгааг онцгойлон анхааруулж байна.

Салхи 4 дүгээр сарын 4-нд Өмнөговь, Дундговийн нутаг, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангайн өмнөд хэсгээр, 5-нд Дундговь, Дорноговь, Сүхбаатарын нутаг, Өмнөговийн зүүн хэсгээр секундэд 18-20 метр, зарим үед секундэд 24 метр хүрч шороон шуурга шуурах тул урьдчилан сэргийлэх чиглэлээр шуурхай арга хэмжээ авна уу.

ДАРГА



С.ЭНХТҮВШИН

27713187

